

ГАРЧИГ

ОРШИЛ.....	3
НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙ НИЙТЛЭГ ОЙЛГОЛТ, ҮНДЭСЛЭЛ.....	4
1.1. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ҮНДЭСЛЭЛ.....	4
1.2. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ.....	4
1.3. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АЧ ХОЛБОГДОЛ.....	5
1.4. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЦАР ХҮРЭЭ, АНГИЛАЛ, ЗАРЧИМ.....	6
1.5. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ОРОЛЦОГЧ ТАЛУУД.....	7
ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АГНУУРЫН БҮС НУТГИЙН ХИЛ ХЯЗГААР.....	9
2.1. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТАНИЛЦУУЛГА, ЭДИЙН ЗАСАГ, УУР АМЬСГАЛ, УРГАМАЛ, АМЬТАН, ГАЗАРЗҮЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ.....	9
2.2. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АГНУУРЫН БҮС НУТГУУДЫН ДЭЛГЭРЭНГҮЙ.....	12
2.2.1. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АГНУУРЫН БҮС НУТГУУД.....	12
2.2.2. АГНУУРЫН БҮС НУТГУУДЫН ХИЛИЙН ЗААГИЙГ ТОДОРХОЙЛСОН КООРДИНАТ.....	14
2.2.3. АГНУУРЫН БҮС НУТГУУДЫН ГАЗРЫН ЗУРАГ.....	15
2.2.4. АГНУУРЫН БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭ, СУДАЛГААНЫ ЯВЦАД ТЭМДЭГЛЭГДСЭН АМЬТНЫ ТОО.....	15
ГУРАВДУГААР БҮЛЭГ. МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, СТРАТЕГИ.....	27
3.1. МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ.....	27
3.2. ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ/ СТРАТЕГИ.....	28
3.3. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ.....	28
3.4. НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА.....	31
3.5. АГНУУРЫН БҮС НУТАГТ АН АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН АМЬДРАХ ОРЧИН, ИДЭШ ТЭЖЭЭЛИЙН БҮЛГЭМДЭЛД УЧИРЧ БУЙ БЭРХШЭЭЛ.....	32
ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ МОНИТОРИНГ.....	34
4.1. АГНУУРЫН БҮС НУТГИЙН МЕНЕЖМЕНТИЙН БҮТЭЦ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР.....	34

4.2. ОРОН НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ	35
4.3. ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГ	37
ХАВСРАЛТУУД НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР	38

ОРШИЛ

Зэрлэг ан амьтан бол Монгол орны үнэт баялаг бөгөөд нөөцийг нь зүй зохистой, хуулийн дагуу ашиглах аваас үржин төлжиж, нөхөн сэргээгдэж байдгаараа улс орны эдийн засагт багагүй хувь нэмэр оруулдаг. Монгол улс тусгай зориулалтын ан агнуурыг 1965 оноос хойш тогтвортой хийлгэж, байгальд ээлтэй тогтвортой ашиглалтыг бий болгохын тулд тухайн цаг үеүүддээ хуулиа шинэчлэн, сайжруулахын төлөө салбарын хүмүүс идэвх санаачлагатай ажилласаар ирсэн билээ. Тогтвортой хөгжлийн үзэл баримтлалд нийцсэн, байгальд ээлтэй зохистой ашиглалт гэдэг нь:

- Тухайн салбарын мэдлэгт тулгуурлан, түүнийг оновчтой тодорхойлох,
- Эрх зүйн орчинг хангах,
- Хэрэгжилтийг хангахуйц амьдрах чадвартай бүтэц бий болгох,
- Мэргэжлийн оролцоог хүртээлтэй болгох зэрэг олон асуудлыг хэрэгжүүлэх зайлшгүй шаардлага агнуур судлалын салбарт бий болж байна.

Ан амьтныг хамгаалахын зэрэгцээ агнуурын нөөцийг зүй зохистой ашиглах нь тогтвортой хөгжлийн нэг зорилт болохыг Монгол улсын нэгдэн орсон, одоог хүртэл хүчин төгөлдөр мөрдөгдөж байгаа олон улсын холбогдох конвенц, байгаль хамгаалал, ан амьтан хамгаалах чиглэлийн нэр хүнд бүхий олон улсын байгууллагуудын үзэл баримтлал, зарчим, дүрэм, журам ч баттай гэрчилж байна.

Одоогоор байгаль хамгааллын салбарын анхаарлаас хөндий орхигдсон нэг асуудал бол ан амьтны нөөцийг зохистой ашиглах ажлыг улсын хэмжээнд оновчтой арга хэлбэрээр зохион байгуулах, хэрэгжүүлэх ажил юм. Нөхөн төлждөг баялагийг зохистой ашигласнаар түүнээс олох ашиг орлого тогтворжиж, улс орны эдийн засгийн эргэлтэнд зохих хувь нэмэр болохын зэрэгцээ ан амьтны хамгаалал сайжирах боломжтой.

Зохистой ашиглалт бол байгаль хамгаалах нэг арга хэрэгсэл болохыг дэлхий дахинаа хүлээн зөвшөөрсөн цаг үед бид амьдарч байна. Дээрх арга хэмжээг ан агнуурын менежментийн төлөвлөгөөгүйгээр явуулах бололцоогүй билээ. Иймээс тус менежментийн төлөвлөгөөнд нутгийн иргэдийн оролцоог зохистой хэлбэрээр хангах, учирч буй аюул дарамтыг бууруулж, хамгаалах, агнуурын нөөцийг тогтвортой ашиглах талаарх арга хэмжээг тусгасан болно.

Энэхүү менежментийн төлөвлөгөөг бүрэн хэрэгжүүлснээр орон нутгийн байгаль орчинд тулгамдаж буй асуудлуудлыг шийдвэрлэж, төр, иргэд, хувийн хэвшлийн хоорондын хамтын ажиллагааны уялдаа холбоог бэхжүүлж, байгаль хамгаалах зорилго зорилтуудыг хамтран үр дүнтэй шийдвэрлэх боломж олгох, нутгийн иргэдэд түшиглэсэн, хамтын байгалийн нөөцийн менежментийг хэрэгжүүлэх боломжтой.

Менежментийн төлөвлөгөөг боловсруулахдаа Монгол улсын төр, Засгийн газраас агнуурын санг хамгаалах, зохистой ашиглах талаар баримталж буй бодлого, дэлхий нийтийн жишиг, чиг хандлагад тулгуурласны зэрэгцээ ерөнхий агнуур зохион байгуулалтын тайланд тулгуурлав.

Төлөвлөгөөг боловсруулахдаа үнэт зүйлээр аргаль хонь, янгир ямаа, халиун буга, зэгсний гахай болон Алтайн тарвагыг сонгов. Менежментийн төлөвлөгөө нь Баян-Өлгий аймагт 2024-2028 онуудад хэрэгжих бөгөөд үндсэн зарчим, аргачлал, онцлог, хамгаалалтын өнөөгийн байдал, байгаль цаг уурын нөхцөл, өөрчлөлт, тэдгээрээс урган гарах бэрхшээл, эрсдлүүдэд хийсэн үнэлгээ, зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны үндсэн чиглэлийг багтаасан болно. Баян-Өлгий аймгийн БОАЖГазар, нутгийн иргэдийн нөхөрлөл,

аймаг, сумын удирдлагуудын идэвхтэй оролцоотойгоор ан амьтны мэргэжлийн байгууллага болох “Агнуур судлалын нийгэмлэг” ТББ тус менежментийн төлөвлөгөөг боловсруулав.

НЭГДҮГЭЭР БҮЛЭГ. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ТУХАЙ НИЙТЛЭГ ОЙЛГОЛТ, ҮНДЭСЛЭЛ

1.1. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ БАЙГАЛЬ ХАМГААЛЛЫН ҮНДЭСЛЭЛ

Ан агнуурын менежментийн төлөвлөгөө нь байгаль орчныг хамгаалах, байгалийн нөөцийг хадгалах, зүй зохистой ашиглах, байгалийн нөөцөд хүний үйл ажиллагаанаас хамааран одоо болон ирээдүйд гарч болзошгүй сөрөг нөлөөллийн учир шалтгааныг тодорхойлох, түүнийг бууруулах арга замыг олох зорилготойгоор боловсруулдаг.

Агнуурын ач холбогдолтой амьтдын тархац нутгийн зарим хэсэгт малын тоо толгойн хэт өсөлт, ган зуд зэрэгээс уялдан бэлчээр, усны хомсдол үүсч, эзэмшил нутгийн давхцал бий болох, бэлчээр нутгаар шахах, хууль бус агнуурт өртөх, дэд бүтцийн төлөвлөлттэй уялдан амьдрах орчин хумигдах зэрэг сөрөг үр дагаварууд гарсаар байна.

Гарч байгаа сөрөг нөлөөллийн учир шалтгааныг буруу тогтоох, орхигдуулснаас, оновчтой үйл ажиллагаа төлөвлөж хэрэгжүүлж чадахгүйд хүрнэ. Тиймээс хүсэн хүлээж буй үр дүндээ хүрэхийн тулд урт хугацаанд олон талаас нь хэлэлцэж, сөрөг нөлөөллийг бууруулах цогц арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх шаардлагатайг харуулж байна.

Эдгээр арга хэмжээнд аймгийн нутаг дэвсгэрт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн агнуур зохион байгуулалтын ажлын тайлан, дүгнэлтийг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөх, амьтны нөөц бүхий агнуурын бүс нутгийг зүй зохистой ашиглаж, хамгаалах менежментийг нутгийн иргэдэд (байгаль хамгаалах нутгийн иргэд, нөхөрлөл) хариуцуулах замаар байгалийн нөөцийн хамтын менежментийг бий болгох зэрэг нь нэн тэргүүний хэрэгжүүлэх зорилт юм.

Ан агнуурын менежментийн төлөвлөгөө нь тухайн аймаг, агнуурын бүс нутгийн амьтан, тэдгээрийн амьдрах орчин, идэш тэжээлийн бүлгэмдэл, экосистемээс төлөөлөл болгон сонгож зайлшгүй хамгаалах агнуурын амьтны зүйлийг тодорхойлон, өнөөгийн төлөв байдалд үнэлэлт, дүгнэлт өгч, тэдгээрт учирч буй болон ирээдүйд учирч болох аюул, дарамтад дүн шинжилгээ хийсний үндсэнд алсын хараа, эрхэм зорилго, зорилт, стратегийг боловсруулж тодорхой хугацааг хамарсан, оролцогч талуудаар хүлээн зөвшөөрөгдсөн, эрх бүхий байгууллагаар баталгаажсан байна.

1.2. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ ЭРХ ЗҮЙН ҮНДЭСЛЭЛ

Монгол Улсын Их Хурлын 2012 оны 5 дугаар сарын 17-ны өдрийн хуралдаанаар шинэчлэн батлагдсан “Амьтны тухай хууль”-д хэд хэдэн шинэ үзэл баримтлалыг тусгасан байдаг. Тухайлбал, Амьтны тухай хуулийн 4.1.11 дэх заалтад тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичиг нь “ан агнуурын менежментийн төлөвлөгөө” байна гэж тусгасан байна.

“Амьтны тухай хууль”-ийн 5.3.2; 5.8.3; 21.4.1; 21.5.3; 22.3; 22.6; 23.1 дэх заалтад ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулан, батлах, хэрэгжүүлэх, хяналт тавих, ан агнуурын менежментийн төлөвлөгөөний дагуу агнуурын бүс нутгийг тогтоож, түүний тодорхой хэсгийг эзэмшүүлэх гэх мэт үйл ажиллагааны зохицуулалт тусгагдсан байдаг.

Баян-Өлгий аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөөний шинэчилсэн хувилбар нь дараах бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэхэд чиглэгдсэн болно. Үүнд:

1. УИХ-аар баталсан Ногоон хөгжлийн 3.2.8-т заасан амьтны хамгаалал, зохистой ашиглалтад нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийн менежментийг төлөвшүүлж, тогтвортой санхүүжилтийн эх үүсвэрийг бүрдүүлэх гэснийг хэрэгжүүлэх болно.
2. УИХ-аар баталсан “Алсын хараа-2050” Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын хүрээнд 2021-2030 онд хэрэгжүүлэх үйл ажиллагаа”-ны 6.1.6-т заасан олон талт байгаль хамгааллын менежмент, техник технологийн хөгжлийг нэвтрүүлж, тусгай хамгаалалттай газар нутгийн менежментийн үр ашигтай байдлыг сайжруулна гэснийг хэрэгжүүлнэ.
3. Засгийн газрын 325 дугаар тогтоолоор батлагдсан Биологийн олон янз байдлын үндэсний хөтөлбөрийн 18 дахь зорилтын хүрэх үр дүнд заасан 2025 он гэхэд агнуурын бүс нутгийн менежментээс нутгийн иргэд, эдийн засгийн үр ашгийг тогтвортой хүртдэг болсон байна хэмээх заалтыг хэрэгжүүлнэ.

1.3. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ АЧ ХОЛБОГДОЛ

Аймгийн болон агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг боловсруулан хэрэгжүүлснээр дараах ач холбогдолтой. Үүнд:

- ✓ Ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагаа нь тухайн аймаг, агнуурын бүс нутгийн агнуурын амьтны нөөц, тархац, амьдрах орчин зэрэг мэдээлэл дээр үндэслэгдэх учраас оновчтой арга хэмжээг хэрэгжүүлэх нөхцөл бүрдэнэ;
- ✓ Агнуурын бүс нутгийн менежментийг хэрэгжүүлэх өдөр тутмын болон дунд хугацааны үйл ажиллагааны удирдамжаар хангаж шийдвэр гаргах, тулгамдсан асуудлаа шийдвэрлэхэд;
- ✓ Агнуурын бүс нутгийн байгаль хамгааллын тасралтгүй байдлыг бий болгоно. Өөрөөр хэлбэл гадаад, дотоод нөхцөл байдал өөрчлөгдөхөөс үл хамааран тасралтгүй үргэлжлэх процесс бий болно;
- ✓ Агнуурын амьтны нөөцийг нэмэгдүүлэхээр дэвшүүлсэн зорилт, үйл ажиллагааны үр дүнг хэмжих нөхцөл бүрдэнэ;
- ✓ Ан агнуурын менежментийн төлөвлөгөө нь тухайн жилд сум, аймгийн төсөвт төвлөрөх санхүүжилтээс байгалийн нөөцийн төлбөрийн тухай хуулийн 18-ын 1дэх зүйл заалтын дагуу орлогын 50%-ийг амьтны хамгаалалд зарцуулахад баримтлах гол баримт бичиг болно;
- ✓ Санхүү, материаллаг бааз болон ажиллах хүчний зохистой төлөвлөлт хийх, хөрөнгөө зөв зарцуулах, хяналт тавих боломж бүрдэнэ;
- ✓ Агнуурын бүс нутаг, агнуурын нөөцийг тогтвортой ашиглах асуудалд оролцогч талуудын хамтын ажиллагааг хөгжүүлэх боломж бүрдэнэ;
- ✓ Ан агнуурын менежментэд оролцогч талуудын агнуурын бүс нутгийн талаарх зөв

ойлголтыг олгохын зэрэгцээ төлөвлөгөөний хэрэгжилтэнд олон талын оролцоог хангасан хяналтыг бий болгох нөхцөл бүрдэнэ;

- ✓ Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилт, үр дүн нь тухайн аймаг, агнуурын бүс нутагт агнуурын амьтныг зохистой ашиглах шийдвэр гаргах үндэс болно.

1.4. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЦАР ХҮРЭЭ, АНГИЛАЛ, ЗАРЧИМ

Монгол улсын Засгийн газрын 2022 оны 01 дүгээр сарын 12-ны өдрийн 19-р тогтоолын нэгдүгээр хавсралтаар батлагдсан “Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллагын ажиллах журам”-д агнуур зохион байгуулалтыг “ерөнхий” ба “нарийвчилсан” гэж ангилсан байдаг.

Ерөнхий агнуур зохион байгуулалтанд аймгийн нутаг дэвсгэрийн улсын тусгай хамгаалалттай газраас бусад газарт агнуур зохион байгуулалт хийж тухайн аймгийн агнуурын бүс нутгийн хилийн зааг, хэмжээг тогтоож, аймаг, сумын Иргэдийн Төлөөлөгчдийн хурлаар батлуулах, аймгийн агнуурын менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулах, холбогдох талуудаар хэлэлцүүлэх, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах үйл явц багтана.

Нарийвчилсан агнуур зохион байгуулалтанд аймгийн ерөнхий агнуур зохион байгуулалтын үр дүнд тодорхойлж, аймаг, сумын иргэдийн Төлөөлөгчдийн Хурлаар хилийн зааг, хэмжээг баталсан агнуурын бүс нутагт агнуур зохион байгуулалт хийж тухайн агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулах, холбогдох талуудаар хэлэлцүүлэх, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулах үйл явц багтана.

Агнуур зохион байгуулалтын цар хүрээнээс шалтгаалан ан агнуурын менежментийн төлөвлөгөөг дараах байдлаар ангилна. Үүнд:

- Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө;
- Агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө гэнэ.

Амьтны тухай хуулийн 5.4.7, 22.3-т аймаг, нийслэл, сум, дүүргийн ИТХ нь агнуурын амьтны тархац нутагт ан амьтныг агнах, барих агнуурын бүс нутгийг агнуурын менежментийн төлөвлөгөөнд үндэслэн тогтооно гэж заажээ. Мөн хуулийн 23.3-т аймаг, нийслэл, сум, дүүргийн засаг дарга харъяалах нутаг дэвсгэртээ агнуур зохион байгуулалтыг таван жил тутамд хийлгэхээр заасан. Иймд агнуурын менежментийн төлөвлөгөөг хуулинд заасан хугацаатай нийцүүлэн таван жилийн хугацаатай боловсруулан, хэрэгжүүлэх бөгөөд шинэчлэн сайжруулж болно.

Менежментийн төлөвлөгөөг боловсруулах зарчим нь түүний цар хүрээ, хэрэгжүүлэгч талуудаас хамааран өөр, өөр байна.

Аймгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч нь аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага, ЗДТГ учир менежментийн төлөвлөгөөний гол зарчим нь амьтны нөөцийг хамгаалах, зохистой ашиглах талаарх аймаг, нийслэлийн бодлого, түүний хэрэгжилтийг хангахад оршино.

Харин агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэгч нь тухайн бүс нутгийг хариуцсан иргэн, нөхөрлөл, хуулийн этгээд учир тухайн нутгийн иргэд, холбогдох талуудын оролцоонд түшиглэх зарчмыг баримтлана.

Агнуур зохион байгуулалтын мэргэжлийн байгууллага нь тухайн аймагтай байгуулсан гэрээний дагуу ерөнхий агнуур зохион байгуулалтыг хийж аймгийн болон агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөнд мэргэжил, арга зүйн зөвлөгөө өгнө.

Харин аймаг, нийслэлийн байгаль орчны асуудал эрхэлсэн байгууллага, ЗДТГ, агнуурын бүс нутгийн менежментийг хариуцагч нь мэргэжлийн байгууллагын боловсруулсан

аймгийн ерөнхий агнуур зохин байгуулалтын тайлан, арга зүйн зөвлөмжид үндэслэн агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөний төслийг боловсруулж, байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулна.

1.5. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНД ТАВИГДАХ ШААРДЛАГА, ОРОЛЦОГЧ ТАЛУУД

Агнуурын менежментийн төлөвлөгөө нь дараах шаардлагуудыг хангасан байна. Үүнд:

- ✓ Байгаль орчны багц хуулиуд, тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарсан дүрэм, журмыг хэрэгжүүлэхэд чиглэсэн байх;
- ✓ Үндэсний болон бүс нутаг, орон нутгийн хөгжлийн бодлого, хөтөлбөртэй уялдсан байх;
- ✓ Менежментийн төлөвлөгөө нь тасралтгүй үйл явц бөгөөд улам боловсронгуй болгон өөрчилж байх боломжтой, уян хатан байх;
- ✓ Менежментийн төлөвлөгөөг боловсруулах, хэрэгжүүлэх, гүйцэтгэлийн хяналтад оролцооны аргыг гол зарчмаа болгосон байх;
- ✓ Менежментийн төлөвлөгөө боловсруулахад тухайн цаг үеийн хэрэгцээ, шаардлагад нийцүүлэн аль болох орчин үеийн шинэлэг арга зүй, төлөвлөлтийн программ ашигласан байх;
- ✓ Менежментийн төлөвлөгөөнд дэвшүүлэх зорилго нь урт хугацааны шинжтэй бөгөөд тухайн агнуурын амьтдын нөөцийг өсгөн нэмэгдүүлэх, амьдрах орчинг сайжруулахад чиглэгдсэн байх;
- ✓ Менежментийн төлөвлөгөөний зорилт нь 5 жилийн хугацаанд биелэгдэхүйц, агнуурын амьтны амьдрах орчин, тоо толгойд учирж буй аюул дарамтын нөлөөллийг бууруулахад чиглэгдсэн байх;
- ✓ Агнуурын амьтны амьдрах орчин, тоо толгойд нөлөөлж буй сөрөг нөлөөллүүдийг нөлөөллийн хүч, цар хүрээ зэрэг шалгуураар дүн шинжилгээ хийж, эрэмбэлсэн байх;
- ✓ Дэвшүүлсэн зорилтонд хүрэх арга зам, үр дүнгийн хэлхээсийг тодорхойлон стратегийг боловсруулсан байх;
- ✓ Төлөвлөлт нь логик дэс дараатай, дүн шинжилгээн дээр суурилагдсан үйл явц байх;
- ✓ Дэвшүүлсэн зорилтондоо хүрэхэд чиглэгдсэн үйл ажиллагаа тус бүр тодорхой зардал шаардах тул түүнийг орхигдуулах юм бол менежментийн төлөвлөгөө маань зөвхөн “хүсэл мөрөөдлийн жагсаалт” болдог. Иймд төсөв санхүүгийн нарийвчилсан тооцоо судалгааг зайлшгүй хийж, эх үүсвэрүүдийг үндэслэлтэй заасан байх;
- ✓ Төлөвлөгөөг хэрэгжүүлэх ажил үүргийн хуваарийг гаргасан байх, хэрэгжилтийг байнга хянах зорилгоор жил, улирлын төлөвлөгөөний гүйцэтгэлийг гаргах зэрэг хяналт, үнэлгээний үйл ажиллагааг тусгасан байх;
- ✓ Менежментийн төлөвлөгөө нь дэвшүүлсэн зорилтууд болон үйл ажиллагаа хоёрын зохистой тэнцлийг хангасан, харьцангуй удаан хугацааны, улс төрийн болон албан тушаалтны хувийн сонирхлын нөлөөллөөс ангид, оролцогч талуудын зүгээс хүлээн зөвшөөрөгдсөн, бие даасан байх;
- ✓ Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилт нь хэмжигдэхүйц шалгуур үзүүлэлтээр хангагдсан,
- ✓ Менежментийн төлөвлөгөө нь эрх бүхий этгээдээр батлагдсан байх зэрэг болно.

Агнуурын бүс нутаг бүр өөрийн онцлог байдлаас шалтгаалан харилцан адилгүй зорилт дэвшүүлж, шийдвэрлэх арга замаа тодорхойлсон төлөвлөгөө боловсруулах шаардлагатай юм.

Ан агнуурын менежментийн төлөвлөгөөнд оролцогч талууд: Сүүлийн 20-иод жилд олон улсад нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийг хэрэгжүүлэх болсон. Энэ нь ан амьтны нөөцийг хамгаалах, тогтвортой ашиглах асуудалд агнуурын бүс нутаг түүний орчимд амьдарч байгаа иргэдийн амьжиргааны асуудлыг хамаарч байгаагаараа онцлогтой юм. Агнуурын бүс нутгийн менежментийн төлөвлөгөөг холбогдох бүхий л талуудын оролцоонд тулгуурлан боловсруулна. Оролцогч талууд анхнаасаа хамтран зөвшилцөж тохиролцвол үйл ажиллагааны хэрэгжилтэнд илүү идэвхтэй оролцдог. Ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулахад оролцогч талуудын төлөөллийг аль болох бүрэн хамруулах нь цаашид агнуурын бүс нутгийн менежментийн зорилго, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд талуудын хамтын ажиллагаанд таатай нөхцөл бүрдэх болно.

Аливаа менежментийн төлөвлөгөөний адил аймгийн болон агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөө боловсруулах үйл явц нь нилээд цаг хугацаа, мэргэжлийн ур чадвар шаардсан цогц үйл ажиллагаа юм. Оролцоог сайжруулахын тулд дараах арга хэмжээг зайлшгүй авч хэрэгжүүлэх шаардлагатай. Үүнд:

1. Ан агнуурын ялангуяа спорт, олзворын, үйлдвэрийн агнуурын үйл явц орон нутагт өгөөжтэй байдлаар зохион байгуулагдахын ач холбогдлыг талуудад таниулан сурталчлах;
2. Менежментийн төлөвлөгөөний ач холбогдлын талаар сурталчилгаа, танилцуулга хийх;
3. Менежментийн төлөвлөгөө боловсруулах үйл явцын талаар талуудад мэдээлэх;
4. Менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг агнуурын бүс нутгийн нөхцөл байдлыг үнэлэх үндсэн шалгуур үзүүлэлт болгох;
5. Төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд санхүүгийн бодитой боломж байгаа эсэхийг тодорхойлох зэрэг болно.

Агнуурын бүс нутаг нь ихэвчлэн 1 сумын нутагт орших боловч цөөн тооны агнуурын бүс нутаг хэд хэдэн сумдын нутгийн заагт оршдог. Иймд төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн аймаг, сум, бүс нутгийг хөгжүүлэх бодлого, стратеги, хөгжлийн бусад баримт бичгүүдтэй нягт уялдуулах шаардлагатай.

ХОЁРДУГААР БҮЛЭГ. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСАГ, БАЙГАЛЬ ОРЧНЫ ӨНӨӨГИЙН БАЙДАЛ, АГНУУРЫН БҮС НУТГИЙН ХИЛ ХЯЗГААР

2.1. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН ТАНИЛЦУУЛГА, ЭДИЙН ЗАСАГ, УУР АМЬСГАЛ, УРГАМАЛ, АМЬТАН, ГАЗАРЗҮЙН ӨНӨӨГИЙН ТӨЛӨВ БАЙДАЛ

АЙМГИЙН ТАНИЛЦУУЛГА: Баян-Өлгий аймаг нь 1940 оны 8 дугаар сард БНМАУ-ын Бага Хурлын шийдвэрээр байгуулагдсан. Монгол Улсын хамгийн баруун хязгаар Монгол Алтайн нурууны далайн түвшинээс 1301-4374 м(нийт нутгийн 95,3 хувь далайн түвшингээс 1600 м-ээс дээш) өргөгдсөн, мөнх цааст өндөр уулсаар хүрээлэгдсэн, 45,8 мянган хавтгай дөрвөлжин км газар нутагтай.

ОХУ-ын Алтайн БН Улс (225 км), БНХАУ-ын ШУӨЗО (450 км), Монгол Улсын Ховд (450 км), Увс (165 км) аймгуудтай хиллэдэг. 103 мянган хүн амтай, үүний 93 хувь казах үндэстэн, үлдсэн хувийг дөрвөд, урианхай, тува, халх ястангууд эзэлдэг. Засаг захиргааны 14 нэгжтэй (13 сум, 1 тосгон), нийслэл Улаанбаатараас 1760 км зайд оршдог, аймгийн төв Өлгий хотод 30 гаруй мянган хүн оршин суудаг. 1,4 сая гаруй малтай.

Байгалийн унаган төрхөө хадгалсан нутаг дэвсгэр нь мөнх цаст сүрлэг өндөр уулс, уудам хөндий хотос, тунгалаг уст гол мөрөн, нуур цөөрөм, рашаан булаг, жимс жимсгэнэ, дэлхийд ховордсон эмийн ургамал, ан амьтан, жигүүртэн шувууд, алт, мөнгө, гянтболд, төмрийн хүдэр, зэс, хар тугалга зэрэг эрдэс баялагийн арвин их нөөцтэй, уул уурхайн үйлдвэрлэл, эрчимжсэн МАА, улс дамнасан худалдаа үйлчилгээ, аялал жуулчлал, худалдаа, эдийн засгийн чөлөөт бүс хөгжүүлэх боломжтой аймаг юм.

ЭДИЙН ЗАСАГ: Эдийн засгийн гол салбар нь мал аж ахуй бөгөөд 1,4 сая малтай, тариалан сул хөгжсөн байна. Аж үйлдвэрийн хөгжил дорой боловч уул уурхай, хөдөө аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулах салбарт тэргүүлэх ач холбогдол өгч, хөгжүүлэх боломжтой, төмөр зам, хатуу хучилттай авто замгүй, холбоо, агаарын болон авто тээврийн үйлчилгээ харьцангуй илүү хөгжсөн.

Хэтийн төлөв сайтай алтны 6 үндсэн илрэл, 5 шороон хуримтлалын зангилаа хэсэг буюу талбайг тогтоосон нь ойрын жилүүдэд эрэл-үнэлгээ, хайгуул хийж, алт олборлолтын салбарыг хөгжүүлэн, үйлдвэрлэлийн хэмжээг нэмэгдүүлэх бололцоотой боловч байгалийн нөөц, баялагийн судалгааг бүрэн хийгээгүй байна. Төсвийн урсгал зардлын 30 гаруй хувийг өөрийн орлогоор, үлдсэн хэсгийг улсын татаасаар бүрдүүлдэг, төсөв санхүүгийн чадавхи сул юм. Аймгийн байгаль орчин нь унаган төрхөөрөө үндэсэндээ хадгалагдсан, ус, хөрс, агаар бохирдуулах уул уурхай, химийн үйлдвэр хөгжөөгүй, малын тоо бэлчээрийн даацнаас хэтэрч, бэлчээр талхлагдан, цөлжих нөхцөл бүрдсэн байна. Байгалийн хязгаарлагдмал нөөц, баялгийг үнэ төлбөргүй ашигладаг үрэлгэн хэв шинжээс бүтээгдэхүүний үйлдвэрлэл, үйлчилгээний үнэд байгалийн өртгийг тусгаж, байгалийн даацад зохицон амьдрах хөгжлийн шинэ хандлагад шилжих арга замыг сонгон хөгжих чиг хандлага нь аймгийн хөгжлийн гол стратеги болж байна.

УУР АМЬСГАЛ: Баян-Өлгий аймгийн нутаг нь далайн түвшнээс дээш 1350-4374 метр өргөгдсөн, өндөр уулсаар хүрээлэгдсэн учир эх газрын эрс тэс уур амьсгалтай. Нутаг дэвсгэр

нь Монгол Алтайн нурууны бүсэд байдаг мөнх цастай, өндөр уул хадтай, шовх сарьдаг, гол мөрний сав газар ихтэй.

Хамгийн өндөр уул Таван богд 4374 м, Цамбагарав 4108 м, Цэнгэл хайрхан 3978 м зэрэг оргилууд оршдог. Монгол Алтайн нурууудын хооронд хотгорууд олон байдаг. Тэдгээрийн томхон нь Даян, Толбо нуурын хотгор юм. Баян-Өлгий аймгийн нутгаар агаарын жилийн дундаж температур сүүлийн /1964-2004 он/ 40 жилд 0,6 градусаар дулаарсанаас дулааны улиралд 0,28 градусаар, хүйтний улиралд 0,55 градусаар дулаарсан.

Жилийн 230-250 хоног нь цэлмэг, өвлийн улирал нь урт /дундажаар 231-255 хоног/, хур тунадас бага, ихэнх нь 6, 7, 8 саруудад ордог онцлогтой. Жилийн хамгийн дулаан сар нь 7-р сар бөгөөд дундаж температур нь Баяннуур, Ногооннуур нутгаар 15.3-18.3 градус, бусад нутгаар 19.5-22.2 градус дулаан байна. Судалгааны материалаас үзэхэд: Өлгий 1995-2002 онд, Баяннуур, Ногооннуур, Булган нутгаар 30,0-38,6 градус хүрч халуун ажиглагдаж байсан байна.

Баян-Өлгий аймагт жилийн турш баруун ба баруун хойноос салхи зонхилдог. Орон нутгийн хотгор гүдгэрээс ихээхэн хамаарна. Аймгийн хэмжээнд салхины дундаж хурд 2-3 м/с байх боловч, хавар намар салхины 15-20 м/с, зарим үед 30-40 м/с хүрч элэгдэл ихээхэн гардаг юм. Ялангуяа Дэлүүн өртөөнд намарт 40 м/с салхи 2 удаа 34 м/с салхи 4 удаа давтагдсан байна.

Хур тунадас ихэвчлэн 6-8 саруудад ордог. Өвлийн саруудад хур тунадас бага ордог.

УРГАМАЛ: Тус аймгийн ургамалжилт нь ерөнхий шинжээрээ өндөр уулын, хагт сөөгөнцөрт, улалж-бушилзат, хүйтсэг чулуусаг алаг өвс-ботуульт өндөр уулын нуга, хээр/, ойн алаг өвс-хөвдөт, улалжит хус-нарс-шинэсэн тайгархаг ой, уулын хээр алаг өвс-ботуульт, улалж-бутнуурт, чулуусаг алаг өвс-үетэнт, хуурай хээр алаг өвс-ерхөг ботуульт, харгана, жижиг үетэн хялганат, чулуусаг алаг өвс ботуульт, харганат, ерхөг- хялганат, цөлжүү хээрийн үетэн хялганат, харгана хазаар өвст, алаг өвст, хээржүү цөлийн харгана, тэсэг, баглуур бүхий хялганат шинжтэй. Ховд голын дагуу бургас, улиас хааяа шинэс, гацуур бүхий улалжит, үетэн-алаг өвст, дэрст голын татмын ургамалжилтай. Эдгээрээс нэрлэвэл: агь, таана, хөмүүл, шаваг, шарилж, ерхөг, хиаг, хазаар өвс, харгана, хялгана, бударгана зэрэг хээр, цөлөрхөг хээрийн өвс ургамал зонхилж, чийг илүүтэй уулын сүүдэр хажууд үхрийн нүд, хад, гүзээлзгэнэ, тошлой зэрэг зэрлэг жимсгэнэ ургадаг. Ой нь уулсын зөвхөн сүүдэр хажууг бүрхэн, өвөр талдаа хээрийн ургамал тархсан, уулархаг нутгаар вансүмбэрүү, бадамлянхау, алтан гагнуур, чихэр өвс, бамбай, башиг, чийгийн давирхай, таван салаа, нохойн хошуу зэрэг олон зүйл эмийн ургамал ургадаг. Монгол орны ургамал-газар зүйн мужлалтаар Евроазийн хээрийн их мужийн, Төв Азийн дэд их мужийн, Говийн умард цөлөрхөг хээрийн мужид хамаарна.

АМЬТАН: Дэлхийд ховордсон аргаль хонь, янгир ямаа, цоохор ирвэс, шилүүс мий зэрэг зэрэг амьтдаас гадна хүрэн баавгай, халиун буга, саарал чоно, шар үнэг, хярс үнэг, мануул мий, хадны суусар, алтайн тарвага, бортуулай, үен зэрэг хөхтөн амьтад. Шувуудаас харцага, ёл, цармын бүргэд, сар, тоншуул, гангар хун, борцгор хотон, алтайн хойлог, алтан гургалдай, хээрийн галуу, хошуу галуу, гангар хун, хар өрөв тас, цагаан сүүлт нөмрөг, цасны хажир, хартоншуул, уран шувуу, нугас зэрэг жигүүртэн шувуудтай бөгөөд Дэлхийн болон Монгол орны “Улаан ном”-д орсон Төв Азийн унаган амьтад олноор амьдрана. Монгол орны амьтны газарзүйн мужлалтаар Уулархаг Азийн дэд их мужийн Монгол төвдийн муж, Монголын хээрийн ба говийн их мужид хамаарна.

ГАЗАРЗҮЙ: Баруун талаараа Алтайн нурууны хяр дагаж БНХАУ-ын Шинжаан-Уйгарын Өөртөө засах оронтой 450 км, хойт талаараа Сийлхэмийн нуруу дагаж ОХУ-ын Бүгд

Найрамдах Алтай Улстай 225 км, зүүн талаараа Увс аймагтай 165 км, зүүн ба урьд талаараа Ховд аймагтай 450 км нутгаар хиллэдэг. Далайн түвшнээс дээш 1301-4374 метрт оршино, нутаг дэвсгэрийн 95,3% нь 1600 метрээс дээш өндөрт байна. Аймгийн хамгийн өндөр цэг нь Монгол улсын хамгийн өндөр цэг болох Алтай Таван Богд уулын Хүйтэн оргил (4374 м) ба хамгийн нам цэг нь Баяннуур сумын төв (1301 м) юм.

Аймгийн нутаг дэвсгэр кайнозойн эриний дөрөвдөгч галавын үеийн гол, мөрөн, нуур, усны ажиллагаагаар тогтсон элс, шавар, хайрга голлосон тунамалтай, уулын хүрэн ба цайвар хүрэн хөрс зонхилсон гол, мөрний саваар нугат намгийн заримдаг давсархаг хөрс, өндөр уулын бүсэд хад асга бүхий уулын тундрын ба уулын нугын хөрстэй, элэгдэл, өгөршлийн ажиллагаагаар тогтсон хонхор, гүдгэр, уул нуруудаас тогтдог. Геологи-тектоникийн мужлалын хувьд Монгол Алтайн атираат мужийн баруун ба баруун хойд хэсэгт оршдог юм. Даян, Хотон, Хоргын цэнгэг устай том, жижиг 80-аад нуур, 100 гаруй гол, горхи, 200 гаруй булаг, шандтай. Толбо, Ачит нуур нь загасны агнуурын нөөцтэй. Ховд, Цагаан, Согоог, Ёлт, Сагсай, Булган, Ганц мод, Бөхмөрөн зэрэг томоохон голтой, Ховд гол 506 км үргэлжилдэг.

ЛАНДШАФТ: Баян-Өлгий аймаг нь өндөр уулын бүс, бүслүүрт орших учраас байгаль цаг уур, хотгор гүдгэр, ус, хөрс, ургамал, амьтан зэрэг байгалийн иж бүрдлээс хамааран ландшафтын дараах хэв шинжүүд ялгарсан байна. Үүнд:

- ✓ Алтайн уулсын ноёлох өндөрлөгүүд дэх орчин үеийн мөстлөг, мөсөн гол зонхилсон ян сарьдагийн ландшафт. Алтай таван богд, Сийлхэм, Их түргэн уул, Цэнгэл хайрхан, Цамбагарав, Хөхсэрх, Мөнххайрхан уул.
- ✓ Алтайн уулсын ноёлох өндөрлөгүүд дэх асга хад бүхий хурц шовх оргил голлосон ян сарьдагийн ландшафт. Мааньт уулаас урагших Монгол Алтайн нурууны хилийн дагуух өндөрлөг хэсгүүд.
- ✓ Алтайн нурууны эртний тэгширлийн гадарга дахь уулын нугын ба уулын тундрын хөрстэй, уулын хээр хосолсон бушилз-улалжит уулын нугын ландшафт. Нутгийн төв болон өмнөд хэсгийн голуудын хөндий дагуу нутгууд.
- ✓ Алтайн нурууны болон саланги тусгаар орших өндөр ба дундаж уулс дахь уулын хуурай хээрийн бүдүүн ялзмагт, уулын хар шороон, хар хүрэн хөрстэй, алаг өвс-хялганат уулын хээрийн ландшафт. Нутгийн хойт болон төв, өмнөт хэсгийн голуудын хөндий дагуу нутгууд
- ✓ Алтайн нурууны болон саланги тусгаар орших өндөр ба дундаж уулс дахь уулын хуурай хээрийн бүдүүн ялзмагт, уулын хар хүрэн хөрстэй, чулуусаг алаг өвс-үетэнт ургамалжилтай уулын хуурай хээрийн ландшафт. Нутгийн зүүн хойт Өлгий хот, Ховд голоос хойших нутаг.
- ✓ Монгол орны дорнод хэсэг болон голын са дагуух нам уулс, өндөрлөг талын хар хүрэн хөрстэй, чулуусаг алаг өвс-үетэнт хуурай хээрийн ландшафт. Ховд голын тохойрсон хэсэг Улаан худгийн хөдөө, Улаанхаргана /дэвэлийн арлын өмнөд/ орчмын нутаг.
- ✓ Их нууруудын хотгор, нууруудын хөндийн өндөрлөг талын цөлийн хээрийн бор хөрстэй, сөөгөнцөр-хялганат ургамалжилтай, шарилж-хялганат заримдаг цөлийн ландшафт. Ачит нуурын баруут талын нутаг.
- ✓ Голын хөндийн ёроол дагуух нутаг намгийн болон нугат мараалаг хөрстэй, алаг өвс-үетэнт ургамалжилтай, бургас-улиасан шугуйтай нугын ландшафт. Ховд голын дагуух, Дэвэлийн арал орчмын нутаг.

2.2. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АГНУУРЫН БҮС НУТГУУДЫН ДЭЛГЭРЭНГҮЙ

2.2.1. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АГНУУРЫН АМЬТДЫН ЭКОЛОГИЙН ҮНЭЛГЭЭ

Хүснэгт 1. Баян-Өлгий аймгийн агнуурын амьтдын экологийн үнэлгээ

Хамгаалах зүйлийн шинж чанар дараах хүчин зүйлүүдтэй холбоотой				
Хэмжээ <ul style="list-style-type: none">✓ Популяцийн хэмжээ✓ Идэвхтэй амьдрах орчны хэмжээ Нөхцөл <ul style="list-style-type: none">✓ Зүйлийн бүрдэл✓ Сүргийн бүтэц (нас г.м)✓ Биологийн харилцаа (үржил г.м) Ландшафт: <ul style="list-style-type: none">✓ Хүрээлэн буй орчны гол нөхцөл (хур тунадас, ус зүй, түймэр г.м)✓ Холбогдох байдал (хоол тэжээл, амьдрах орчинд шилжих боломж, тархах, нүүдэллэх, шинээр нутагших г.м)				
Хамгаалах зүйл	Одоогийн ангилал			
	Хэмжээ	Нөхцөл	Ландшафт	Амьдрах чадварын ангилал
Аргаль хонь	Сайн	Сайн	Дунд	Сайн
Янгир ямаа	Сайн	Сайн	Дунд	Сайн
Халиун буга	Сайн	Сайн	Сайн	Сайн
Зэгсний гахай	Сайн	Сайн	Сайн	Сайн
Тарвага	Маш сайн	Сайн	Дунд	Сайн

2.2.2. БАЯН-ӨЛГИЙ АЙМГИЙН АГНУУРЫН БҮС НУТГУУД

Баян-Өлгий аймаг нь 13 сум 1 тосгонтой. Аргаль хонины 17, янгир ямааны 15, халиун бугын 4, зэрлэг гахайн ,, агнуурын бүс нутагтай. Энэ удаагийн судалгаагаар аргаль хонины ,, янгир ямааны ,, халиун бугын ,, зэрлэг гахайн ,, бүс нутаг шинээр тогтоолоо.

Шинээр нэмэгдэж буй агнуурын бүс нутгууд:

1.

- 2.
- 3.

Шинээр нэмэгдэж буй агнуурын бүс нутгийг сонгосон шалгуур:

- Орон нутгийн удирдлагын санал, хүсэлт
 - Спорт агнуурын чиглэлээр зөвшөөрөл олгогдож, агнуур эрхэлж байсан туршлагатай эсэх,
 - Тухайн агнуурын бүс нутагт тусгай зөвшөөрлөөр агнагддаг агнуурын амьтдын нөөцтэй эсэх,
 - Орон нутгийн иргэд, нөхөрлөлийн оролцоонд тулгуурласан агнуурын менежментийг хэрэгжүүлэх нөхцөлд хамтран оролцож үр шимийг нь хүртэх, хамгаалалтын ажилд идэвхтэй оролцох сонирхолтой эсэх, зэрэг шалгуурыг хангасанд тооцов.
- **Хасагдаж буй агнуурын бүс нутгууд:**
 - 1.
 - 2.

Хасагдаж буй агнуурын бүс нутгийн шалтгаан:

Хүснэгт 2. Баян-Өлгий аймгийн агнуурын бүс нутаг

№	Сумдын нэр	Агнуурын бүс нутгийн нэр	Агнуурын амьтдын нэр				
			Аргаль хонь	Янгир ямаа	Халиун буга	Зэгсний гахай	Тарвага
1	Алтай	Халуун бардам, Шарговь АБН	+	+			
		Цалгарын цагаан булаг АБН	+				
2	Алтанцөгц	Мундуйн дэвсэг АБН		+			
		Улаан харгана АБН				+	
3	Баяннуур	Уушгийн улаан АБН		+			
						+	
4	Бугат	Тошинт АБН		+			
		Төмөрт АБН	+				
		Бугын гол АБН				+	
5	Булган	Улаагчин АБН	+	+	+		

		Рашаант-Ендэрт		+	+			
6	Буянт	Эзэрлэг АБН	+					
7	Дэлүүн	Аххунт АБН	+	+	+			
		Дэлүүн АБН	+	+				
		Улаанговь АБН	+					
8	Ногооннуур	Бахлаг АБН		+				
		Бураат АБН	+					
		Модон овоо АБН		+				
		Хавцал АБН		+				
		Хөх хөтөл АБН	+					
		Хар арал АБН				+		
9	Өлгий	АБН-гүй						
10	Сагсай	Арцат-Мөст уул АБН	+	+				
		Бөхөн АБН	+					
11	Толбо	Борт АБН		+				
		Зурхайчийн нуруу АБН	+	+				
		Сайр уул АБН		+				
12	Улаанхус	Агуйт хатуу АБН	+					
		Мянган уул АБН	+					
		Монгол гол АБН	+					
13	Цэнгэл	Баян цэнгэл АБН	+					
		Бор бургас АБН			+			

2.2.2. АГНУУРЫН БҮС НУТГУУДЫН ХИЛИЙН ЗААГИЙГ ТОДОРХОЙЛСОН КООРДИНАТ

2.2.3. АГНУУРЫН БҮС НУТГУУДЫН ГАЗРЫН ЗУРАГ

2.2.4. АГНУУРЫН БҮС НУТГИЙН ХЭМЖЭЭ, СУДАЛГААНЫ ЯВЦАД ТЭМДЭГЛЭГДСЭН АМЬТНЫ ТОО

Хүснэгт 2. Баян-Өлгий аймгийн агнуурын бүс нутгийн хэмжээ, тоологдсон амьтны тоо толгой

Баян-Өлгий аймаг

Тархац, байршил: Баян-Өлгий аймгийн Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Буянт, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Толбо, Улаанхус, Цэнгэл сумдын нутагт аргаль хонь тархсан байна.

Хүснэгт 8. Баян-Өлгий аймгийн аргаль хонины тархац, байршил, сумдаар

№	Сүм	Тархац нутаг	Талбай, км ²	Тоо толгойн мэдээлэл
1	Алтай	Буянтын нурууны Урд, Хойд бардам, Мухар тошинт, Улаан хад, Угалзын салаа	7,297.82	АБН-ийн мэдээлэл
2	Алтанцөгц	Зуслан уул, Намаржааны хөтөл, Эрэгтийн голын эх, Цаст уулын хэсэг		Мэдээлэл хомс
3	Баяннуур	Цаст уулын хойд хэсэг, Таван бэлчир, Эрэгт		Мэдээлэл хомс
4	Бугат	Их, Бага Асгат, Мөст, Ногоон нуурын эх, Хөх хөтөл даваа, Хойлогийн уул, Загийн Улаан уул, Хойлогийн даваа, Заагт хөтөл, Орогт уул, Төмөрт уул, Төмөртийн хөндий, Орогтын эх, Хаянгийн голын эх, салаанууд		АБН-ийн мэдээлэл
5	Булган	Улаагчины голын эхэн, Агуйтын нуруу, Арцат, Улаан сайр уул, Хар ацын даваа, Хар нуурын нолын эхэн хэсэг		АБН-ийн мэдээлэл
6	Буянт	Тошинт, Эзэрлэгийн нуруу, Буянтын нуруу		АБН-ийн мэдээлэл
7	Дэлүүн	Агуйтын нуруу, Модон ахуунт, Хөх Сэрхийн нуруу, Бор цоохор уул		АБН-ийн мэдээлэл
8	Ногооннуур	Хөхийн уул, Хөхтийн цагаан жинст, Салхит, Жалгын хөтөл, хил орчмын нутаг		АБН-ийн мэдээлэл
9	Сагсай	Өмнө голын хоёр талын уулс, Дунд уул, Нарийн нуруу, Бөхөн уул		АБН-ийн мэдээлэл
10	Толбо	Зурхайчийн нуруу, Сайр уул, Бураат, Шар судаг, Хатуугийн эхний уул		АБН-ийн мэдээлэл
11	Улаанхус	Сийлхэмийн нуруу, Гурван гайшинсар, Баянзүрхийн нуруу, Агуйт, Хүрэн уул, Асгатын нуруу, Мянган уул Хүрэн хайрхан, Их ойгорын голын эхний уулс		АБН-ийн мэдээлэл

12	Цэнгэл	Их ойгорын голын эхний уулс, Талдагийн их уул, Баян уул,	Мэдээлэл хомс
----	--------	---	---------------

Нягтшил, нөөцийн үнэлгээ: Баян-Өлгий аймгийн хэмжээнд аргаль хонь тархсан 15 байршил газрын 7,297.82 км² талбайд 1,000 га-д 4.82 бодгаль нягтшилтайгаар 3,520±659 толгой нөөцтэй байх бололцоотой байна.


Хүснэгт 9. Баян-Өлгий аймгийн аргаль хонины тархац, нөөцийн үнэлгээ, оноор

Аргаль хонины тархац, нөөц	Судалгаа хийгдсэн он					
	2001	2008	2009	2014	2018	2023
Тархац нутаг, км ²	2,408.0	7,443.75	4,244.3	6,744.17	4,055.9	7,297.82
Нөөц /толгой/	1,050	2,382	2,123	3,237	3,098	3,520
Нягтшил /1000 га-д/	4.4	3.2	5.0	4.8	7.6	4.82

График 6. Баян-Өлгий аймгийн аргаль хонины тархац, нөөцийн харьцуулсан үзүүлэлт



Зураг 6. Баян-Өлгий аймгийн аргаль хонины тархац



Баян-Өлгий аймаг

Тархац, байршил: Баян-Өлгий аймгийн Алтай, Алтанцөгц, Баяннуур, Бугат, Булган, Дэлүүн, Ногооннуур, Сагсай, Толбо, Улаанхус, Цэнгэл сумдын нутаг дэвсгэр Алтайн нуруу түүний салбар уулс Цамбагарав уул, Хөх Сэрх, Сийлхэм, Баянзүрх, Хүнгүйн нуруу зэрэг газруудад янгир ямаа тархан байршиж байна.

Хүснэгт 46. Баян-Өлгий аймгийн янгир ямааны тархац, байршил, сумдаар


№	Сум	Тархац нутаг	Талбай, км ²	Тоо толгойн мэдээлэл
1	Алтай	Цагаан уул, Холагаш уул, Өвчүүн уул,	14,251.06	Мэдээлэл хомс
2	Алтанцөгц	Цамбагарав, Ямаат,		АБН-ийн мэдээлэл
3	Баяннуур	Цамбагарав, Ямаат, Чулуун овоот, Хавчуугийн өндөр уул, Хэнгэрэгт орчим		АБН-ийн мэдээлэл
4	Бугат	Бахлаг, Тошинг, Хатуугийн гол, Хүнгүйн нуруу		АБН-ийн мэдээлэл
5	Булган	Мөнх хайрханы нуруу, Баянзүрх, Хар Бөөрөг уул, Сайрт өндөр уул		Мэдээлэл хомс, АБН-ийн мэдээлэл
6	Дэлүүн	Хөх Сэрхийн нурууны Бүргэд уул, Шар дэвсэг, Мухар дэвсэг, Баруун хайрхан уул, Хавцалт өндөр уул, Мараа уул		ТХГН-ийн мэдээ
7	Ногооннуур	Годронгийн нуруу, Шуугиант уул, Сээр уул, Хар сайрын уул, Их Түргэн уул, Онгорхой уул, Асгат уул, Ямаат уул, Хэнгэрэгт уул, Ихэр уул, Хавчуугийн өндөр		АБН-ийн мэдээлэл, Мэдээлэл хомс
8	Сагсай	Шанагат уул, Их чулуут уул, Мөнх хайрхан уул, Ирмэгтэйн даваа		Мэдээлэл хомс
9	Толбо	Сайр уул, Зурхайчийн нуруу,		ДБХС, АБН мэдээ
10	Улаанхус	Хатуугийн гол, Баян уул, Шар ямаат, Өндөр хайрхан уул, Хар хад уул,		АБН-ийн мэдээлэл
11	Цэнгэл	Ирвэстийн даваа, Алтай Таван богд орчмын Цагаан хайрхан, Мөрөгцөг уул, Битүү уул, Дөнгөрөх уул, Асгат, Шивээт хайрхан		Мэдээлэл хомс

Нягтшил, нөөцийн үнэлгээ: Баян-Өлгий аймгийн янгир ямаа тархсан 17 байршилд 14,251.06 км² талбайд 1,000 га-д 2.92 бодгаль нягтшилтайгаар 4,154±657 толгой нөөцтэй байх бололцоотой.

Хүснэгт 4 7. Баян-Өлгий аймгийн янгир ямааны тархац, нөөцийн үнэлгээ, оноор

Янгир ямааны тархац, нөөц	Судалгаа хийгдсэн он				
	2001	2009	2014	2018	2023
Тархац нутаг, км ²	-	7,522.3	9,096.83	3,602.0	14,251.06
Нөөц /толгой/	-	3,874	3,365	3,127	4,154
Нягтшил /1000 га-д/	-	5.15	3.7	8.68	2.92

Зураг 24. Баян-Өлгий аймгийн янгир ямааны тархац



Тарваганы дундаж нягтшил, нөөц


д/д	Сумын нэр	Талбайн хэмжээ \га\	Тарвага тархсан нутаг \га\	Дундаж нягтшил	Нөөцийн үнэлгээ
1	Алтанцөгц	178610	3572	0.3	1071
2	Баяннуур	233950	5848	0.4	2339
3	Алтай	316556	25300	0.7-0.8	18975
4	Бугат	204910	20491	0.6	12294
5	Булган	497733	49773	1.2	59727
6	Буянт	184567	18456	0.8	14765
7	Сагсай	313999	31390	0.6-1.1	26681
8	Толбо	297469	29740	0.7-1.4	28253
9	Ногооннуур	522194	52219	0.5-1.3	46997
10	Дэлүүн	559499	56000	0.5-1.0	42000
11	Улаанхус	604793	60200	1.5-1.7	96320
12	Цэнгэл	643317	61000	0.8-1.1	57950
	ДҮН	4570489	413989	-	407372

Судалгааны дүн:

Энэ зүйлийн талаар мэдээлэл дутмаг, агнуурын хэмжээ их өндөр, ой мод ашиглалт, ойн түймэр, орчны доройтол зэрэг олон аюул нүүрлэж байна.

д/д	Сум, газрын нэр	Ажиглалт хийсэн		Нутгийн иргэдээс цуглуулсан аман мэдээгээр үзсэн гахайн сүргийн бүтэц, тоо толгойн байдал					Тэмдэглэл (сэг зэм, хэвтэр, бусад)
		Огноо \ цаг	Талбайн хэмжээ кв.км	Нийт	Бодон	Мэгж	Торой	Тодорхойгүй	
1	Ногооннуур, Шар Модон	09.18, 19 \ 06.30-13.00, 18.30-24.30	24	12	1	2	9	-	Шар Модны Харгай гэдэг газраас үзсэн. (2023 оны 08.10-ны үед) Гахайн хэвтэр 1 бна. Махаббатын намаржааны орчимд, сумын төвөөс зүүн хойт зүгт ... км зайнд байна гэж сумын Засаг дарга, БОХУБ хоёулаа хэлсэн.
	Ногооннуур, Хар-Арал	09.19	8	8	1	1	6	-	Шар Модны Харгай-д N49.17499, E090.42303, Alt 1526 m, (Х.Туяхбай байгаль хамгаалагчийн мэдээлэл)
2	Бугат, Хөндийн арал	09.20 \ 06.30-13.00, 18.30-24.30	36	7 1	1 1	1 -	5 -	- -	Хөндийн аралд хэд хоногийн өмнө 2 томтой, 5 торойг үзсэнээ ярив. 09.24-ны орой 18.00 цагийн орчимд Хөндийн аралд 1 том бодон үзсэнээ ярьж, утсанд бичсэн бичлэгээ С.Галым бидэнд

									үзүүлэв. Бичлэг дээр нь гахайн зураг гэх зүйл ялгарч харагдахгүй л байсан.
3	Алтанцөгц, Хөх Модон, Бэлчир, Бүрхээлт, Хөх хад, Улаан Харгана	09.21 \ 06.30-13.00, 18.30-24.30	8	-	-	-	-	-	Хөх Модон, Бэлчир, Бүрхээлт, Хөх хад, Улаан Харгана орчимд энэ жил гахай үзэгдээгүй гэж М.Наранхүү хэлэв.
4	Баяннуур, Цастын арал, Мөргөлжин, Цагаан хөшөөний арал	09.22, 23 \ 06.30-13.00, 18.30-24.30	16						Цастын аралд 1-2-оор гахайн явсан мэдээ бий. Хэвтэр байгаа гэх боловч зааж өгч чадахгүй байв.Айлын 5 хонь, 2 ямаа идсэн. Ногооны талбайгаас 1 тн орчим төмс идсэн гэж б/х-ч Ж.Ерболат хэлэв.
5	Баяннуур, Цагаан-Арал	09.24 \ 06.30-13.00, 18.30-24.30	20	1	-	-	-	1	Цагаан-Арал багт 2 том арал бий. Дээд аралд нь 1980-д оны дундуур зэгсний гахайн 1 бодон, 1 мэгж,5 торойтой 1 сүрэг гахай хэвтрээс нь үргээж гарган агнаж байсан бол энэ удаад гахай үзсэнгүй. Нутгийн иргэд их байгаа, мал идсэн гэх боловч гахай үзүүлж чадсангүй.
ДҮН			96	29	4	4	20	1	



Судалгаагаар 7 хоногт цуглуулсан нутгийн иргэдийн аман мэдээгээр:

Зэгсний гахай эдгээр 4 суманд өвөл, хавар, зун, намарт үзэгддэг бөгөөд зарим хүмүүсээс тоо толгойн талаар болон нас, хүйсийг нь асуухад яг тодорхой тоо хэлэх нь ховор байв. Ерөнхийдөө уулзсан хүн болгон малыг нь хороож байгаа болохоор “гахай их өссөн байна” гэсэн мэдээлэл өгч байв.

Ховд голын сав дагуух Баяннуур сумын Цастын арал, Мөргөлжин, Цагаан хөшөөний орчимд (Цагаан хөшөө гэдэг нь хүн чулуун хөшөө), Цагаан-Арал багт дээд, доод гэсэн 2 том арал бий, тэнд гахай харагдаж бас л айлын мал их идэж байна гэснээс биш яг тодорхой хэдээр харагдаж байгаа гэх мэдээлэл байхгүй байна:


3.2. ЗЭРЛЭГ ГАХАЙН БИОЛОГИЙН НӨӨЦ

Бид хээрийн судалгаагаар 4 сумын хэмжээнд мэдээ цуглуулж 878 км² зэрлэг гахайн тархац нутгийг тогтоов. Судалгаар аймгийн хэмжээнд 379±41 биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 2. Зэрлэг гахайн нөөц (сумдаар)

№	Сумын нэр	Сумын нийт талбай, км ²	Зэрлэг гахайн тархсан талбай (км ²)	Дээж талбай (км ²)	Дээж талбайд тэмдэглэгдсэн тоо	Тархац нутаг дахь нөөц (толгой)	Дээж талбайн тархац нутагт эзлэх хувь
1	Баяннуур	2339.5	287	87.00	44	145	30.3
2	Алтанцөгц	1801	245	84.00	38	111	34.3
3	Ногооннуур	2389.2	157	51.00	22	68	32.5
4	Бугат	3032	189	65.00	19	55	34.4
5	ДҮН	9561.70	878.00	287.00	123	379	32.7
6	Stdev					41.2	

Диаграмм 1. Зэрлэг гахайн сүргийн бүтэц



14-р диаграмм: Сүргийн бүтцийн харьцааг үзвэл 34 буюу 28% нь бодон, 43 буюу 35% мэгж, 46 буюу 1837% нь тоорой байна.

Диаграмм 2. Бодон, Мэгжийн хүйсийн харьцаа



15-р диаграмм 100 эхэд оногдох илий нь тухайн популяцийн төлжилтийн хувийг илэрхийлдэг. Бодон, мэгжийн харьцаа тухайн популяцийн бүтэц хэвийн байгаа эсэхийг тодорхойлоход гол үзүүлэлт болдог. Энд бодон болон мэгжийн харьцаа тоймловол 1:1,2 байгаа нь энэ нутагт хүйсний харьцаа хэвийн байгааг харуулж байна.

3.3. ХАЛИУН БУГЫН НӨӨЦ


Бид хээрийн судалгаагаар 6 сумын хэмжээнд мэдээ цуглуулж 2420,22 км² халиун бугын тархац нутгийг тогтоов. Бидний судалгаар аймгийн хэмжээнд 307±52 биологийн нөөцтэй байна.

Хүснэгт 3. Халиун бугын нөөц (сумдаар)

№	Сумын нэр	Сумын нийт талбай, км ²	Халиун бугын тархсан талбай (км ²)	Дээж талбай (км ²)	Дээж талбайд тэмдэглэгдсэн тоо	Тархац нутаг дахь нөөц (толгой)	Дээж талбайн тархац нутагт эзлэх хувь
1	Цэнгэл	6710.6	814.12	245.00	44	146	30.1
2	Сагсай	3306.1	506.1	138.00	6	22	27.3
3	Улаанхус	6213.5	76	25.00	0	0	32.9
4	Булган	5051.1	378	121.00	22	69	32.0
5	Дэлүүн	5803.8	432	96.00	10	45	22.2
6	Алтай	3237	214	72.00	8	25	33.6
7	ДҮН	30322.10	2420.22	697.00	90	307	28.8
8	Stdev					52.0	


Зураг.8 Баян-Өлгий аймгийн Халиун бугын тархац, байршил

Диаграмм 3. Бугын сүргийн бүтэц




11-р диаграмм: Сүргийн бүтцийн харьцааг үзвэл 29 буюу 32% нь буга, 35 буюу 39% согоо, 16 буюу 18% нь зоргол, 11 буюу 10% илий байна.

Диаграмм 4. Буга, согооны хүйсийн харьцаа



12-р диаграмм 100 эхэд оногдох илий нь тухайн популяцийн төлжилтийн хувийг илэрхийлдэг. Буга, согооны харьцаа тухайн популяцийн бүтэц хэвийн байгаа эсэхийг тодорхойлоход гол үзүүлэлт болдог. Энд буга, согооны харьцаа тоймловол 1:1,2 байгаа нь энэ нутагт хүйсний харьцаа хэвийн байгааг харуулж байна.

Диаграмм 5. Согоо, зорголын харьцаа



13-р диаграмм Нөхөн үржил: Популяцийн нөхөн үржлийн чадавхийг 100 эхэд ноогдох 1 настай бодгалийн буюу бие даах чадвартай, хамгийн бага насны бодгалийн харьцаагаар тогтоох нь зүйтэй байдаг. 35 согоо, 16 зоргол тэмдэглэсэн. Эндээс харахад халиун бугын популяцийн нөхөн үржлийн чадавхи 31% байна.

№	Смын нэр	АБН	Аргаль хонь							
			Угалз				Хомь	Төлөг	Хураа	Нийт
			I	II	III	IV				
1										

ГУРАВДУГААР БҮЛЭГ. МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ, СТРАТЕГИ

3.1. МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ЗОРИЛГО, ЗОРИЛТ

❖ ЭРХЭМ ЗОРИЛГО

Баян-Өлгий аймгийн менежментийн төлөвлөгөөний эрхэм зорилго нь агнуурын зүйлүүд даацтайгаа зохицон өсч, үржих нөхцлийг хангах, амьдрах орчныг нь хадгалан хамгаалах, орон нутгийн иргэдэд өгөөжтэй ашиглалтыг тогтвортой хөгжүүлэх нөхцлийг хангахад оршино.

Энэхүү менежмент төлөвлөгөөний эрхэм зорилго нь тогтвортой хөгжлийг хангах, удирдлага, зохион байгуулалтыг орчин үеийн шаардлагад нийцүүлэхэд чиглэгдэж доор дурдсан зорилтуудыг хангаснаар биелэгдэх болно. Үүнд :

Зорилт 1. Байгаль орчны хуулийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтийг орон нутгийн захиргаа, иргэд, нөхөрлөлтэй хамтран сайжруулах,

Хүрэх үр дүн: Нутгийн иргэдийн байгаль орчны хуулийн мэдлэг сайжирч, хууль бус байгалийн нөөц ашиглалт бууран иргэд хуулийн дагуу байгалийн нөөцийг ашиглах сэдэлтэй болох ба агнуурын амьтдад үзүүлэх дарамт багасна.

Зорилт 2: Хяналт шалгалт, мониторингийн ажлыг сайжруулах.

Хүрэх үр дүн: Байгалийн нөөцийн мэдээллийн сан үүсгэж, амьтны нөөц болон байгаль орчны өөрчлөлтийг хянах механизм бүрдэнэ

Зорилт 3: Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах

Хүрэх үр дүн: Агнуурын бүс нутгийн амьтны нөөц баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, аялал жуулчлалаас нутгийн иргэд орлого олох боломж бүрдэн ан амьтны амьдрах орчны сөрөг нөлөөлөл буурна..

Зорилт 4. Бэлчээрийн менежментийг сайжруулах

Хүрэх үр дүн: Бэлчээрийн даац, хуваарилалтад иргэдийн ойлголт нэмэгдэж, зүй зохистой ашиглалт бий болон мал аж ахуйн зүгээс зэрлэг амьтдад үзүүлэх сөрөг нөлөө багасна.

❖ ХАМРАХ ХҮРЭЭ

Энэхүү менежментийн төлөвлөгөө нь Баян-Өлгий аймагт 2024-2028 онд хэрэгжинэ.

Менежментийн төлөвлөгөөний дээрх зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхдээ бүх талын хамтын оролцоонд тулгуурлан тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудаас эхлэн хэрэгжүүлж байх нь зүйтэй. Уг төлөвлөгөөний бүх үйл ажиллагаа нь дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд оршино.

3.2. ЗОРИЛТЫГ ХЭРЭГЖҮҮЛЭХ АРГА ЗАМ/ СТРАТЕГИ.

Стратеги 1: Мониторингийн судалгааг удаан хугацаанд хэрэгжүүлэн, популяцид нөлөөлөх сөрөг нөлөөллийг бууруулах арга хэмжээг судалгааны дүнг үндэслэн төлөвлөж хэрэгжүүлэх

Стратеги 2: Агнуурын бүс нутгийг бүрэн хариуцах чадварыг хуулийн этгээдэд олгох, хуулийн этгээдтэй хамтран ажиллаж мэдлэг, туршлага эзэмшүүлэх, эрх зүйн таатай орчныг бий болгох

Стратеги 3: Ашиглалтаас болон бусад боломжтой бүх эх үүсвэрээс тогтвортой санхүүжилтээр хангах

Стратеги 4: НИТАМ хэрэгжүүлэх чадварыг менежмент хариуцагч ба нөхөрлөлд эзэмшүүлэх, төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт мониторинг хийх чадвар олгох

3.3. СТРАТЕГИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЛ АЖИЛЛАГААНЫ ТӨЛӨВЛӨГӨӨ, ТӨСӨВ

Хүснэгт 4. Менежментийн төлөвлөгөөний зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэх үйл ажиллагааны төлөвлөгөө

Үйл ажиллагаа	Хугацаа /он/	Төсөв /төг/	Гүйцэтгэх байгууллага	Үр дүн, баталгаа
Зорилт 1. Байгаль орчны хуулийн мэдлэгийг нэмэгдүүлэх, хуулийн хэрэгжилтийг орон нутгийн захиргаа, иргэд, нөхөрлөлтэй хамтран хэрэгжүүлэх,				
1.1. Шинээр батлагдсан байгаль орчны чиглэлийн хууль, тогтоомж, дүрэм, журам, тушаал шийдвэрийг цаг тухайд нь иргэд, нөхөрлөлд мэдээлэх, сургалт, сурталчилгаа зохион байгуулах	2024/2027	35 сая	БОАЖГ, “Сумдын ЗДТГ”, мэргэжлийн байгууллага	Танилцаалга хийсэн зураг, хөтөлбөр
1.2. Хууль сурталчлах, хууль бус агнуурын эсрэг сурталчилгааны аян зохион байгуулах	2024/2028		БОАЖГ, мэргэжлийн байгууллага	Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо, тайлан
1.3. Байгаль хамгаалагчдын хариуцлагыг дээшлүүлэх, чадваржуулах сургалт	2024/2028		БОАЖГ, мэргэжлийн байгууллага	Сургалтын хөтөлбөр, оролцогчдын тоо, тайлан
1.4. Урсгал зардал		10 сая	“БОАЖГ”, “Сумдын ЗДТГ”	Тайлан, зарцуулсан мөнгөн дүн
Хүрэх үр дүн: Нутгийн иргэдийн байгаль орчны хуулийн мэдлэг сайжирч, хууль бус байгалийн нөөц ашиглалт бууран иргэд хуулийн дагуу байгалийн нөөцийг ашиглах сэдэлтэй болох ба агнуурын амьтдад үзүүлэх дарамт багасна.				
Зорилт 2: Хяналт шалгалт, мониторингийн ажлыг сайжруулах.				
2.1. Талуудын хамтран ажиллах нөхцөл, үүрэг хариуцлагыг харилцан тохиролцон гэрээ	2024/2028	-	БОАЖГ, “Сумдын ЗДТГ”, мэргэжлийн байгууллага	Байгуулсан гэрээ

	байгуулах				
2.2.	Агнуурын бүс нутагт нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийлгэх	2024/2028	-	БОАЖГ, мэргэжлийн байгууллага	Нарийвчилсан агнуур зохион байгуулалт хийгдсэн байх
2.3.	Биологийн олон янз байдлын судалгаа мониторингийн хөтөлбөр боловсруулах	2026	50 сая	Аймгийн ЗДТГ, БОАЖГ	Боловсруулсан хөтөлбөр, хэрэгжилтийн тайлан
2.4.	Гэрээний биелэлтийг жил бүр дүгнэж, хэлэлцэх	2024/2028	-	БОАЖГ, “Сумдын ЗДТГ”	Гэрээг дүгнэсэн хурлын тэмдэглэл
2.5.	Мониторинг судалгааг тогтворжуулах, судалгааны үр дүн боловсруулах	2024/2028	3 сая	БОАЖГ, мэргэжлийн байгууллага	Боловсруулалт хийсэн тайлан
2.6.	Хууль бус ан агнуурын үйл ажиллагаанд хяналт шалгалт хийх	2024/2028	20 сая	БОАЖГ, “Сумдын ЗДТГ”	Шалгалтын үр дүнгийн тайлан
2.7.	Идэвхтэн байгаль хамгаалагчдын ажлыг дүгнэн урамшуулж байх системийг бүрдүүлэх	2024/2028	10 сая	БОАЖГ, “Сумдын ЗДТГ”	Үнэлгээний аргачлал, дүн

Хүрэх үр дүн: Байгалийн нөөцийн мэдээллийн сан үүсгэж, амьтны нөөц болон байгаль орчны өөрчлөлтийг хянах механизм бүрдэнэ.

Зорилт 3: Нутгийн иргэдэд түшиглэсэн байгалийн нөөцийг хамгаалах, зохистой ашиглах

3.1.	Байгалийн нөөцийн мэдээллийн санг баяжуулах (биологийн төрөл зүйл, бэлчээр, гол, булаг шанд)	2024/2028	10 сая	БОАЖГ	Мэдээллийн сантай болсон байна.
3.2.	Байгалийн гамшгаас сэргийлэх, эрсдлийг бууруулах	2024/2028	20 сая	БОАЖГ	Нөөцөлсөн өвс, тэжээл, давс хужирын хэмжээ, тайлан, зураг
3.3.	Биотехникийн арга хэмжээ авах (Ган зудтай үед хэрэглэх хадлан, тэжээл, хужир, давс бэлтгэн нөөцлөх)	2024/2028	50сая	БОАЖГ, “Сумдын ЗДТГ”	
3.4.	Отгийн стандартыг бий болгох мөрдүүлэх	2024/2028	-	БОАЖГ	-
3.5.	Аялал жуулчлалын бүтээгдэхүүний сурталчилгаа хийх, үзэсгэлэн худалдаанд оролцох	2024/2028	15 сая	БОАЖГ	Оролцсон үзэсгэлэн

Хүрэх үр дүн: Агнуурын бүс нутгийн амьтны нөөц баялгийг зүй зохистой ашиглах, хамгаалах, аялал жуулчлалаас нутгийн иргэд орлого олох боломж бүрдэн ан амьтны амьдрах орчны сөрөг нөлөөлөл буурна.

Зорилт 4. Бэлчээрийн менежментийг сайжруулах

4.1.	Агнуурын бүс нутгуудын бэлчээрийн даацыг тогтоолгох	2024/2028	10 сая	БОАЖГ, “Сумдын ЗДТГ	Судалгааны тайлан
4.2.	Бэлчээрийн менежментийг нэвтрүүлэх	2024/2028	35 сая	БОАЖГ, “Сумдын ЗДТГ	
4.3.	Уст цэгийг хамгаалах, шинээр бий болгох	2024/2028	15 сая	БОАЖГ, “Сумдын ЗДТГ	Уст цэгийн хамгаалах ажил хийгдсэн байх
4.4.	Агнуурын бүс нутгийн малчдын өвөлжөө, хаваржаа, намаржаа, зуслангийн зураг гаргах	2024/2028	-	БОАЖГ, “Сумдын ЗДТГ	Бэлчээрийн даацад тохирсон улирлын хуваарь

Хүрэх үр дүн: Бэлчээрийн даац, хуваарилалтад иргэдийн ойлголт нэмэгдэж, зүй зохистой ашиглалт бий болон мал аж ахуйн зүгээс зэрлэг амьтдад үзүүлэх сөрөг нөлөө багасна.

Нийт төсөв	291.000.000 сая
-------------------	------------------------

Менежментийн төлөвлөгөөний дээрх зорилго, зорилтуудыг хэрэгжүүлэхдээ бүх талын хамтын оролцоонд тулгуурлан тухайн үеийн нөхцөл байдлыг харгалзан нэн тэргүүнд авч хэрэгжүүлэх шаардлагатай ажлуудаас эхлэн хэрэгжүүлж байх нь зүйтэй. Уг төлөвлөгөөний бүх үйл ажиллагаа нь дэвшүүлсэн зорилтуудыг хэрэгжүүлэхэд оршино.

3.4. НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ШААРДЛАГА

Агнуурын менежментийг хэрэгжүүлэх үндсэн зарчмыг өөрчлөх шаардлага өнгөрсөн жилүүдийн буруу практикаас үүдэлтэйгээр урган гарч байна. Хэдэн жилийн өмнө “Ашиглагч нь хамгаалагч байна” гэсэн зарчмыг баримталж байсан нь зөвхөн ашиглах сонирхолыг илүү төрүүлж, хамгаалалтын ажил нь хоцрогдох байдал их гарч байсан. Иймд, дээрх зарчмыг “хамгаалагч нь ашиглах давуу эрхтэй байна” гэсэн зарчмаар өөрчлөх шаардлага гарч байна. Өөрөөр хэлбэл, хамгаалах талаар санаачлагатай ажиллаж байгаа иргэд, аж ахуйн нэгж, байгууллага ашиглах давуу эрх эдлэх ёстой бөгөөд энэ нь агнуурын менежментийг үр бүтээлтэй хэрэгжүүлэх үндэс юм. Орон нутгийн иргэд тухайн газар орон, байгалийн нөхцөл, түүний өөрчлөлтийн талаар хэнээс ч илүү мэдээлэлтэй байдаг, ан амьтныхаа төлөө хэнээс ч илүү сэтгэл гарган ханддаг. Иймд нутгийн иргэдэд түшиглэсэн менежмент нь үндэслэл, хэрэгжих боломжоороо ямагт илүү байна.

Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийн зарчим

- ❖ Популяцид хал багатай, тогтвортой удаан хугацаанд ашиглах
- ❖ Ашиг нь орон нутгийнхны амьжиргааг дээшлүүлэхэд чиглэгдэх
- ❖ Орлогын тодорхой хувийг хамгааллын менежментэд зарцуулж байх
- ❖ Хамгааллын менежментийн төлөвлөгөөтэй байх
- ❖ Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежмент хэрэгжүүлэгчид нь тодорхой сургалтанд хамрагдан мэргэшсэн байх
- ❖ Мэдээллээ нээлттэй ил тод байлгах
- ❖ Аливаа асуудлыг дотооддоо ардчилсан зарчмаар шийддэг байх
- ❖ Мэргэжлийн байгууллагын дүгнэлт, саналыг хугацаанд нь заавал хэрэгжүүлдэг байх зэрэг зарчмуудыг баримтлах шаардлагатай

Тусгай зориулалтын ан зохион байгуулах

- Агнуурын менежментийг хэрэгжүүлэгч нь орон нутгийн төр, захиргааны байгууллага иргэдийн нөхөрлөлтэй хамтран агнуурын бүс нутагтаа “Нарийвчилсан агнуур зохион байгуулалт”-ыг захиалан хийлгэж дүгнэлт, зөвлөмжийг нь хэрэгжүүлж байх
- Нутгийн иргэдэд түшиглэсэн агнуурын менежментийн гол зорилго нь агнуураас тодорхой орлого олж байх явдал. Үүний тулд агнуурын зүйлүүдийн популяцийг мониторингийн хэлбэрээр байнга хянаж, мэдээ цуглуулж байх шаардлагатай. Энэ нь ашиглалтад өртөж буй зүйлүүдийн популяци эрүүл байгаа эсэхийг үнэлэх боломж олгоно. Мониторинг нь давуу ба сул талуудтай.

Давуу тал нь:

- ✚ Популяци хэвийн эсэхийг үнэлэх боломжтой болно.
- ✚ Мэдээллийн сан шинэ мэдээгээр байнга баяжигдана.

Сул тал нь:

- ✚ Урт удаан хугацаа шаарддаг
- ✚ Зардал өндөр гардаг
- ✚ Хэрэглэж байгаа арга хэрэгслэлээ байнга хэлэлцэж орчин үеийн шаардлага, стандартуудад нийцүүлэн шинэчилж байх хэрэгтэй болдог.

3.5. АГНУУРЫН БҮС НУТАГТ АН АМЬТАН, ТЭДГЭЭРИЙН АМЬДРАХ ОРЧИН, ИДЭШ ТЭЖЭЭЛИЙН БҮЛГЭМДЭЛД УЧИРЧ БУЙ БЭРХШЭЭЛ

Бэлчээрийн нөөц, амьдрах орчинд учирч буй бэрхшээл.

Засгийн газрын 286 дугаар тогтоолын дагуу Ус цаг уур, орчны судалгаа, мэдээллийн хүрээлэнд 2023-2024 оны өвөл, хаврын бэлчээрийн даацыг баг бүрийн бэлчээрийн ургац, малын тоо, бэлчээрийн талбайн хэмжээ, бэлчээр ашиглах хугацаа зэрэг мэдээлэл дээр үндэслэн багийн нутгаар тооцоолж гаргав. Бэлчээрийн даацыг тооцоолж гаргасан дүнгээс үзвэл нийт нутгийн:

- 3,8 % – Бэлчээрийн нөөцтэй
- 10,1 % – Бэлчээр хүрэлцээтэй
- 25,3 % – Даац 1-3 дахин хэтэрсэн
- 33 % – Даац 3-5 дахин хэтэрсэн
- 27,8 % – Даац олон дахин хэтэрсэн байна.

Өөрөөр хэлбэл өвөл-хаврын бэлчээрийн даац нутгийн 10 орчим хувьд хүрэлцээтэй байхаар, харин 25,3 хувьд даац 1-3 дахин, 33 хувьд даац 3-5 дахин хэтэрч гарлаа. Сумын дүнгээр авч үзвэл Баяннуур, Ногооннуур, Толбо, Буянт, Сагсай, Булган сумын ихэнх, Алтай, Цэнгэл, Дэлүүн, Алтанцөгц сумын зарим багийн нутгаар даац олон дахин хэтэрч гарсан байна.

Бэлчээрийн доройтол нь зөвхөн ХАА-д төдийгүй, мөн зэрлэг амьтдын тоо толгой, тархац байршилтад сөрөг нөлөө үзүүлдэг.

Иймд бэлчээрийн менежментийг сайжруулах нь байгаль орчин, зэрлэг амьтдыг хамгаалах чухал арга хэмжээ юм. Уур амьсгалын өөрчлөлтийг бэлчээр ашиглалтын менежментэд зайлшгүй тусгах шаардлагатай.

Бидний судалгааны хугацаанд аймгийн нутаг дэвсгэр дэхь зэрлэг амьтдын ундаалах боломжтой бүх уст цэгүүдэд малчид нутаглаж, мал сүрэг зэрлэг туруутан амьтдын бэлчээр ус давхацсан байна. Ийм нөхцөлд зэрлэг ан амьтдын популяцийг хамгаалах, өсгөж үржүүлэх боломж хязгаарлагдах юм. Иймд бидний зүгээс зэрлэг ан амьтдыг хамгаалахын тулд аймгийн бэлчээр ашиглалтын менежментэд дараах арга хэмжээг тусгах хэрэгтэй гэж үзэв.

ЗӨВЛӨМЖ: Бэлчээрийн даац олон дахин хэтэрч гарсан дээрх сумдад мал өвөлжих, хаваржих нөхцөл хүндрэхээр байгаа тул тухайн орон нутгийн зүгээс зөв зохион байгуулалт хийж ажиллахыг зөвлөж байгаа бөгөөд энэхүү бэлчээрийн даацын асуудал нь зэрлэг ан амьтны бэлчээр нутагт ч гэсэн хамааралтай тул АБН-ийн хариуцагч компани болон нөхөрлөлүүд анхааралдаа авч бэлтгэл ажлыг сайн хангах хэрэгтэй. Бэлчээрийн даац хэтэрэлт нь зөвхөн энэ онд тохиолдож байгаа биш бөгөөд цаашид ч үргэлжлэх тул үүнд аймгийн БОАЖ-ын газар, аймгийн Хөдөө аж ахуйн газар, сумдын ЗДТГ анхаарч ажиллах нь зүйтэй.

Нөхөн сэргээх арга хэмжээ. Ан амьтны амьдрах орчныг сайжруулахад чиглэсэн арга хэмжээнд ан амьтныг тухайн байршиж буй орчинд нь тогтвортой өсгөн үржүүлэх, хамгаалах, зохистой ашиглахын тулд амьдрах орчныг нь сайжруулах ажлыг тогтмол хийх шаардлагатай. Үүний тулд дараах арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх нь зүйтэй.

- ✓ Ан амьтанд өвс, тэжээл тавьж өгөх, биотехникийн арга хэмжээ авах
- ✓ Хоргодох , нуугдах, бүгэх нөхцлийг бий болгох, сайжруулах
- ✓ Давс хужир тавих, мараажуулах
- ✓ Булаг шанд, худаг тохижуулж усны хангамжийг сайжруулах
- ✓ Ан амьтдыг шинээр буюу сэргээн нутагшуулах
- ✓ Байгалийн гамшигт нэрвэгдсэн ан амьтдыг аврах

ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ. АН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТ ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ ҮНЭЛГЭЭ МОНИТОРИНГ

4.1. АГНУУРЫН БҮС НУТГИЙН МЕНЕЖМЕНТИЙН БҮТЭЦ, САНХҮҮГИЙН ЭХ ҮҮСВЭР

Схем 1. Амьтныг хамгаалах, нөөцийг зохистой ашиглах үйл ажиллагааны удирдлагын бүтэц



Санхүүгийн эх үүсвэр: Менежментийн төлөвлөгөөнд тавигдсан зорилтуудыг хэрэгжүүлэхэд нийт 198 сая төгрөг шаардагдах тооцоо гарч байна.

- Талуудыг чадавхижуулах, удирдлага, зохион байгуулалтын үйл ажиллагаанд
- Судалгаа мониторингийн хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд
- Сургалт, сурталчилгаа, хяналтын үйл ажиллагаанд

Хэрэгжүүлэх байгууллага : Ан агнуурын менежментийг аймгийн Байгаль орчин, Аялал жуулчлалын газар хэрэгжүүлнэ.

Санхүүжилт : Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 18.1-д заасны дагуу тусгай зориулалтаар агнаж, барьсан ан амьтны төлбөрийн орлогын 50-аас доошгүй хувийг агнуурын бүс нутгийн ан агнуурын менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд зарцуулна. Үндсэн санхүүжилт нь агнуураас орох орлого боловч бусад эх үүсвэрээс (хариуцагч компаний тусламж, хандив, өөрийн орлого г.м) дэмжлэг авч болно. Энэхүү менежментийн төлөвлөгөөний зорилго, түүнд тусгагдсан үйл ажиллагаануудыг Уул уурхайн байгаль, амьтан хамгаалах менежмент төлөвлөгөөтэй уялдуулан хамгааллын ажлыг гүйцэтгэх

боломжтой. Менежментийн төлөвлөгөө хэрэгжих хугацаанд төр, засгийн газрын бодлогод орох өөрчлөлтүүдтэй уялдан шаардлагатай үед нэмэлт өөрчлөлт хийж болно.

4.2. ОРОН НУТГИЙН ИРГЭДЭД ТҮШИГЛЭСЭН АГНУУРЫН МЕНЕЖМЕНТИЙГ ХЭРЭГЖҮҮЛЭХ ҮЕ ШАТ

Орон нутгийн иргэдэд түшиглэсэн ан амьтныг хамгаалах хамтын менежментэд нутгийн иргэдийг бэлтгэх, тухайлбал, хөдөлмөрөө хоршиж хоршоо, хамтлаг, нөхөрлөл байгуулах замаар орон нутгийн засаг захиргаатай хамтран ан амьтны нөөцийг ашиглах, ан агнуурын холбогдолтой гарсан зөрчлийг шийдэх энгийн хэлбэр бүтцийг бий болгох эрх зүй, эдийн засгийн орчинг бүрдүүлэх явдал юм.

“Амьтны тухай хууль”-ийн 24.3 дугаар зүйлд агнуурын амьтныг үйлдвэрлэлийн, ахуйн, тусгай гэсэн гурван зориулалтаар агнаж барихаар хуульчлан тогтоожээ. Иргэн ахуйн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад эрхийн бичиг, иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад тусгай зөвшөөрөл тус тус авч, үйлдвэрлэлийн зориулалтаар агнуурын амьтан агнах, барихад гэрээ байгуулна.

Өнөөдрийн байдлаар дээрх 3 зориулалтын ан агнуурыг зохион байгуулж байгаа тогтолцоонд үндсэн 2 үе шат тод харагдаж байна.

1-р үе шат : Агнуурын үйл ажиллагаанд бэлтгэх

1. Ахуйн болон үйлдвэрлэлийн агнуурын амьтдыг ашиглах зөвшөөрлийг хуваарилах механизм

- 1.1. Тухайн амьтны үржил, нөхөн үржих процессд сөрөг нөлөө үзүүлэхгүй бусад хуулийг зөрчихгүй байх үндэслэлээр агнуурын бүс нутгийн хил хязгаарыг тодорхой цаг хугацаатайгаар тогтоож, баримтлах дүрэм, журмыг баг, сумын түвшинд иргэдтэй хамтран боловсруулах, тухайн сум, баг, аймгийн ИТХурлаар батлуулан хуульчлах,
- 1.2. Амьтны тухай хуулийн 3.3 дугаар заалт (сум, дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн хурал агнуурын амьтны байршил нутагт үйлдвэрлэлийн, ахуйн болон тусгай зориулалтаар агнуурын амьтан агнах, барих бүс тогтоож болно гэж заажээ)-д тусгасны дагуу дээрх дүрэм журмыг сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлаар баталгаажуулах
- 1.3. Агнуурын бүс нутаг дахь агнуур зохион байгуулалтыг иргэд, мэргэжлийн байгууллагуудтай хамтран хуулинд заасан хугацаанд зохион байгуулах
- 1.4. Агнуурын амьтдын нөөцийг зохистой ашиглах, хамгаалах менежментийн төлөвлөгөө боловсруулах, агнуурын амьтдын нөөцийг тогтоох
- 1.5. Агнуурын бүс нутаг, агнуурын менежмент, агнуур зохион байгуулалтын тайланг аймгийн ИТХ-аар хэлэлцүүлж баталгаажуулах
- 1.6. Аймгийн ИТХ нь агнуурын бүс нутаг, менежмент төлөвлөгөө, агнуур зохион байгуулалтыг үндэслэн хуваарилалтыг суманд хийх
- 1.7. Сумын ИТХ нь хуваарилалтыг Байгаль орчны тухай хуулийн 3-р зүйлийн 2-р хэсгийн 8 дахь заалтад заасны дагуу нөхөрлөл байгуулан оршин суугаа нутгийнхаа тодорхой төрлийн ан амьтныг хамгаалах, холбогдох хууль

тогтоомжийн дагуу гэрээгээр ашиглах, эзэмших асуудлыг гэрээний дагуу хуваарилах

1.8. Тухайн агнуурын бүс нутгийн агнуурын амьтдын нөөцийг хамгаалах, нөхөн сэргээх, өсгөх зорилгоор агнуур явуулах үйл ажиллагааг хориглох

2. Тусгай зөвшөөрлийн агнуурын амьтан агнах зөвшөөрөл олгох

Байгаль орчны сайдын 2022 оны 19 дугаар тушаалаар баталсан “Ховор амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журам”-ын хавсралтад: Тусгай зориулалтын ан амьтан агнах, барих зөвшөөрлийг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон тухайн сумын засаг даргын албан бичгээр тус тус олгоно гэж тогтоосныг үндэслэн:

2.1. Тусгай зөвшөөрлийн агнуурын амьтны бүс нутгийг тухайн сумын ИТХ-аар хэлэлцэж тогтоох

2.2. Тусгай зөвшөөрлийн агнуурын амьтдын нөөцийг иргэдийн нөхөрлөлийн оролцоотой мэргэжлийн байгууллагаар тогтоох

2.3. Тусгай зөвшөөрлийн агнуурын амьтдыг зохистой ашиглах, хамгаалах үйл ажиллагааг энэ журмын 1.4-д заасан агнуурын менежментэд тусгасан байх

2.4. Тухайн жилд агнах тусгай зөвшөөрлийн дээд хязгаарыг аймгийн ИТХ энэ журмын 1.1, 1.2, 1.3 -т заасан баримт бичгийг үндэслэн тогтооно.

2.5. Тухайн жилд нутаг дэвсгэртээ агнуулах тусгай зөвшөөрлийн ангийн тоо хэмжээний саналыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад хүргүүлэх

2.6. Байгаль орчин, аялал жуулчлалын яам “Ховор амьтан агнах, барих зөвшөөрөл олгох журам”-ын дагуу тухайн сумын Засаг даргын албан бичгийг үндэслэн зөвшөөрлийг олгоно.

3. Ан агнуур эрхлэх аж ахуй нэгжид тавигдах шаардлага

3.1. Ан агнуурын жуулчлал эрхэлж байсан ажлын дадлага, туршлага бүхий мэргэжлийн боловсон хүчин, материаллаг бааз, хөрөнгийн чадавхитай байх

3.2. Гадаад харилцаа, дараа онд хийхээр төлөвлөсөн ангийн урьдчилсан гэрээ, хэлцэлтэй байх

3.3. Байгаль хамгаалах, нөхөн сэргээх талаар тодорхой хийж гүйцэтгэсэн ажилтай байх

3.4. Эрх авсан аж ахуйн нэгж байгууллагын хувьд хуваарьт ангаа бүрэн борлуулсан, ангийн болон төлбөр, хураамжийн тооцоог хугацаанд нь хийж гүйцэтгэсэн байх

3.5. Ангийн олзворын болон ан амьтныг гадаадад гаргах үнийн зах зээлийн судалгаанд үндэслэгдсэн ангийн олзворын үнийн зөв бодлого явуулах менежментийг бүрдүүлсэн байх

3.6. Нутгийн иргэдэд түшиглэсэн зэрлэг амьтны менежментийг хэрэгжүүлэх чадавхтай байх

3.7. Агнуурын үйл ажиллагааг заасан нутаг дэвсгэрээс өөр газар зохион байгуулах, ангийн болон сум, орон нутаг, Орон нутгийн иргэдийн нөхөрлөл байгууллагад оруулах төлбөр тооцоог хийгээгүй, дутуу хийсэн, хугацаандаа хийгээгүй, Орон нутгийн иргэдийн албан ёсны нөхөрлөлийн үйлчилгээг аваагүй тохиолдолд агнуур хийх эрхийг олгохоос татгалзах

- 3.8. Агнуур зохион байгуулалт, менежмент төлөвлөгөөний тайланг Орон нутгийн Засаг захиргааны байгууллага, Иргэдийн нөхөрлөлд албан ёсоор ирүүлэх

2-р үе шат. Агнуурын үйл ажиллагааг зохион байгуулах

Ахуйн болон үйлдвэрлэлийн агнуурыг зохион байгуулах

1. Байгаль хамгаалах хуулийн этгээд, иргэдийн бүлэг, нөхөрлөл сумын Засаг даргатай хийсэн гэрээний дагуу агнуурын бүс нутагтаа агнуурын үйл ажиллагааг зохион байгуулах
2. Сумын байгаль орчны байцаагч, байгаль хамгаалагч, иргэдийн нөхөрлөл агнуурын үйл ажиллагаанд хяналт тавих
3. Агнуурын бүтээгдэхүүний борлуулалтаас орлогын 10-аас доошгүй хувийг дундын санд төвлөрүүлэх
4. Агнуурын үйл ажиллагааны тайланг сумын ИТХ-д оруулж хэлэлцүүлэх
5. Аймгийн ИТХ-д танилцуулах

Тусгай зөвшөөрлийн агнуурыг зохион байгуулах

1. Тусгай зөвшөөрөл авсан компани 2.10-т заасан гурвалсан гэрээний дагуу агнуурын агнуурын бүс нутагт зохион байгуулах
2. Агнуур зохион байгуулсан гэрээний биелэлтийг 3 тал хамтран хэлэлцэж, дүгнэх
3. Дээрх дүгнэлтийг сумын ЗДТГ-т хүргүүлж сумын ИТХ-аар хэлэлцүүлэх
4. Сумын ИТХ-аар хэлэлцсэн дүнг аймгийн ИТХ-д танилцуулах, тайланг хүргүүлэх

4.3. ҮНЭЛГЭЭ, МОНИТОРИНГ

Менежментийн төлөвлөгөөнд хяналт мониторинг хийх чиглэлийг доорх байдлаар тодорхойлж байна. Үүнд :

1. Нөхөрлөл хэрхэн чадавхижсан, хамгаалалтын ажилд хэр зэрэг идэвхитэй оролцож байгаад,
2. Агнуурын зүйлүүдийн нөөц, амьдрах орчны байдал, тэдгээрийн хамгаалалтын чадавхид гарсан өөрчлөлт нь менежментийн төлөвлөгөөний зорилтыг ханган биелүүлэх шаардлагын хэмжээнд хүрч байгаа эсэхэд,
3. Агнуур нь тавигдаж буй шаардлага, зарчимд хэр зэрэг нийцтэй болсон, байгальд болон нутгийн иргэдийн амьжиргаанд хэрхэн үр дүнтэй нөлөөлж байгаад,
4. Орон нутгийн удирдлага, нөхөрлөлийн гишүүдийг байгаль хамгаалах хууль, тогтоомж, экологийн мэдлэг олгох сургалтанд хэрхэн хамруулсан, энэ нь үр дүнд хүрч байгаа эсэхэд,
5. Менежментийн төлөвлөгөөг хэрэгжүүлснээр тухайн бүс нутгийн агнуурын амьтны популяци, амьдрах орчинд өөрчлөлт гарсан эсэх зэрэгт чиглэсэн мониторинг хийх,
6. Аймгийн БОАЖГ-аас жил бүр менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийн явцад мониторинг ба үнэлгээ жил бүр хийж байх.
7. Менежментийн төлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх явцад зөрчил, доголдол илрэх нь мэдээж бөгөөд үүнд зохих хууль тогтоомжийн дагуу шийдвэр гарган засаж

залруулах, хариуцаж буй байгууллага, албан тушаалтанд арга хэмжээ авах, урамшуулах зэрэг хариуцлагын механизм шударга үйлчлэх ёстой.

Энэхүү хуулийн дагуу авсан арга хэмжээ нь талууд, оролцогчдод жигд үйлчлэх ба бусдад үр нөлөө өгөхүйц байх хэрэгтэй.

Менежментийн төлөтөлөвлөгөөний зорилтуудыг хэрэгжүүлэх талаар авах арга хэмжээний үр дүнг дараах шалгуураар үнэлж дүгнэж болно. Үүнд :

1. Байгаль орчны газрын үйл ажиллагааны арга барил, цар хүрээнд гарсан өөрчлөлт, багаар ажилласан чадварын үзүүлэлт,
2. Оролцогч талуудтай хамтын ажиллагаанд гарсан өөрчлөлт, дэмжигчдийн хүрээ өргөжсөн үзүүлэлт,
3. Ан амьтны тоо, толгойн ба ба тархац даацдаа хүртэл өссөн буюу түүний тогтвортой байдал хэрхэн хадгалагдаж байгаа, мөн амьдрах орчны үзүүлэлтүүд,
4. Нөхөрлөлүүд мэргэжлийн боловсон хүчнээр хангагдсан байдал,
5. Ан амьтан хариуцсан мэргэжилтэн, байгаль хамгаалагчид, нөхөрлөлийн гишүүд ажил үүргээ хэрхэн биелүүлж байгаад үнэлэлт дүгнэлт өгөх, улмаар урамшуулах, шагнах, хариуцлага тооцож байх нэгдсэн механизм бүрэлдэн тогтсон байх,
6. Холбогдох хууль тогтоомжийг сурталчлах, экологийн мэдлэг олгох, талуудын оролцогчдыг сургах, хяналт шалгалт хийх зохиох байгуулалтын оновчтой тогтолцоо буй болж төлөвшсөн байх,

Хяналт мониторингийг төрийн захиргааны төв болон орон нутгийн байгууллагууд, хяналтын байгууллагууд өөрсдийн эрх мэдлийн хүрээнд төлөвлөгөөндөө тусган хэрэгжүүлж болно.

ХАВСРАЛТУУД НЭР ТОМЪЁОНЫ ТАЙЛБАР

- “Агнуурын бүс нутаг” гэж агнуурын нөөцийг тогтвортой ашиглах, хамгаалах зориулалт бүхий ан амьтны байршил, тархац нутгийг; (“Амьтны тухай” хууль, 4.1.9.)
- “Агнуурын амьтны сан” гэж Монгол Улсын нутаг дэвсгэр дэх унаган, нутагшсан буюу нүүдлийн агнуурын хөхтөн амьтан, шувуу, загаснаас бүрдэнэ. (“Амьтны тухай” хууль, 2.2.1.)
- “Ан агнуурын менежментийн төлөвлөгөө” гэж тухайн засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж дэх агнуурын бүс нутагт ан амьтныг хамгаалах, тогтвортой ашиглах, өсгөн үржүүлэхэд чиглэгдсэн ан агнуурын арга хэмжээний хүрээнд гүйцэтгэх ажлыг тодорхой үе шаттайгаар цогц байдлаар хэрэгжүүлэхээр төлөвлөсөн баримт бичгийг; (“Амьтны тухай” хууль, 4.1.11.)
- “Агнуурын амьтан” гэж арьс, үс, мах болон бусад түүхий эдийг нь ашиглахаар агнаж ирсэн уламжлалтай, агнуурын нөөцтэй амьтныг, (“Амьтны тухай” хууль, 4.1.7)
- “Агнуурын нөөц” гэж агнуурын амьтны биологийн нөөцөөс хэвийн өсөлт, үржилтийг алдагдуулахгүй агнах, барих боломжтой тоо хэмжээ (“Амьтны тухай” хууль, 4.1.8)

- “Трофейн буюу олзворын ан” ан амьтны илүү үзүүлэлт бүхий эд, эрхтнийг авах зорилгоор тусгай төлбөр төлж агнах, барих үйлийг (“Амьтны тухай” хууль, 4.1.16);
- “Спорт ан” гэж анчин ан агнах, барих хэрэгцээгээ хангах зорилгоор ан амьтны эд, эрхтнийг үзүүлэлтийн хувьд сонголт болгоггүй агнах, барих үйлийг (“Амьтны тухай” хууль, 4.1.15);

Товчилсон үгийн тайлбар

АБН	- Агнуурын бүс нутаг
АЗБ	- Агнуур зохион байгуулалт
БОАЖЯ	- Байгаль орчин, аялал жуулчлалын яам
БОАЖГ	- Байгаль орчин, аялал жуулчлалын газар
ДБХС	- Дэлхийн байгаль хамгаалах сан
НИТААМ	- Нутгийн иргэдэд түшиглэсэн ан агнуурын менежмент
ОНТХГ	- Орон нутгийн тусгай хамгаалалттай газар
ТЗТБ	- Төрийн захиргааны төв байгууллага
НҮТББ	- Нийгэмд үйлчилдэг төрийн бус байгууллага

